



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/137

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Наран тулгуур” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгад “Нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх” чиглэлээр өрөө тасалгаа буулгалт, шинэчлэлтийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд: Д.Нямтулга	- Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Жамбалдорж	- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
Ц.Цолмонбаатар	- Стандарт хэмжилзүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
Ц.Даваасамбуу	- Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
С.Батдорж	- Аймгийн Архивын тасгийн дарга
Г.Энхжин	- “Наран тулгуур” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Наран тулгуур” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН